

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ БАЯНХОНГОР НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.05.14

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн ИНЕГ-ын харьяа орон нутаг дахь зарим нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 06/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн. Удирдамжийн дагуу аудит шалгалт 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал байсан боловч Улаанбаатар хот болон Баянхонгор аймагт цар тахлын улмаас хатуу хөл хорио тогтоосон, Баянхонгор аймаг дахь нисэх буудлын ажилчид Ковид-19 өвчний ойрын хавьтал болсон шалтгаанаар гэртээ тусгаарлагдсан, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 23 дугаар тушаалын дагуу төлөвлөгөөт бус аудитын шалгалт давхацсан зэргээс шалтгаалан шалгалтын хугацаа сунгагдсан болно.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Баянхонгор нисэх буудлын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нисэх буудлын 2020 оны санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Нислэгийн хөдөлгөөний хэсэг, Холбоо, навигаци, цахилгааны хэсэг, Газрын тусгай үйлчилгээний хэсэг, Аюулгүй байдлын хэсэг болон уурын зуухны баг нь 2021 онд хийх ажлын төлөвлөгөөгөө боловсруулж нисэх буудлын даргаар батлуулж, төлөвлөсний дагуу ажлаа гүйцэтгэж тайлагнаж байна.

Галын бүлэг, хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, дотоод хяналт хариуцсан ажилтнууд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан нисэх буудлын даргаар батлуулан хэрэгжүүлж байна.

Нисэх буудлын барилгын өнгө төрхийг сайжруулах зорилгоор буудлын барилгын гадна фасадыг шинэчлэхээр орон нутгийн төсвөөс 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж фасадын ажлыг эхлүүлээд байна.

Ажлын цагийн нэгтгэлийг буруу гаргаснаас цалин хөлсний тооцоогоор 1 ажилтанд 75,605.00 төгрөг дутуу, 1 ажилтанд 232,010.00 төгрөг илүү олгосон.

Авлагыг барагдуулах талаар ажиллаж байгаа ч дорвитой үр дүнд хүрээгүй байна.

Шилэн дансны цахим системд мэдээлэл оруулах үйл ажиллагаа эрс сайжирч, алдаагүй, зөв оруулдаг болсон байна.

Дотоод хяналтын багийн үйл ажиллагаа муу, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт хангалтгүй түвшинд хийгдэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээр сургалт зохион байгуулж, идэвх гарган ажиллаж байгаа хэдий ч сургалтын үр дүнтэй байдал, ажилтнуудад мэдлэг олгосон нотолгоог бүрдүүлэх, шалгалт авах ажлыг орхигдуулсан байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг засаж, залруулах талаар тус нисэх буудалд 8 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА